



Хөвсгөл орчмын Улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын хамгаалалт, үйл ажиллагааг сайжруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тогтвортой хамтын ажиллагаа бий болгох уулзалтын тайлан



Хөвсгөл аймаг, Хатгал тосгон
2009.10.05

**Хөвсгөл орчмын Улсын тусгай хамгаалалттай
газар нутгуудын хамгаалалт, үйл ажиллагааг сайжруулахад олон нийтийн
оролцоог нэмэгдүүлэх, тогтвортой хамтын ажиллагаа
бий болгох уулзалтын тайлан**

Уулзалт зохион байгуулах хугацаа: 2009 оны 09 сарын 23 – 10-р сарын 02

Хамрах хүрээ:

Мөрөн, Баянзүрх, Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Цагааннуур сумдын

- ЗДТГ
- ИТХ
- Төрийн байгууллага
- Төрийн бус байгууллага
- ААН
- Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөл
- Иргэд
- ЕБС-ийн сурагчид

Уулзалтын зорилго: Хөвсгөл орчмын УТХГН-уудын хамгаалалт, үйл ажиллагааг сайжруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, оролцогч талуудтай тогтвортой хамтын ажиллагааг бий болгох

Үйл ажиллагаа:

- Иргэд, ЕБС-ийн сурагчид, хамтран ажиллах талуудад сурталчилгаа хийх
 - Санал солилцох ярилцлага
 - Тэмцээн зохион байгуулах
 - Сурталчилгаа хийх
- Хамтран ажиллах талуудтай уулзалт зохион байгуулах, хамтын шийдвэр гаргах

Уулзалтаас гарах үр дүн:

1. ТХГН-ийн талаархи иргэдийн мэдлэг нэмэгдэнэ
2. Хамтран ажиллах бүлгүүд сонгогдоно, хамтын ажиллагааны чиглэлүүд тодорхой болно, тогтвортой хамтын ажиллагаа бий болно
3. ТХГН дахь үйл ажиллагааны тодорхой чиглэлүүдээр тогтвортой хамтын ажиллагааг бий болгосноор үйл ажиллагааны хамрах хүрээ өргөжиж тухайн чиглэл дэх зардал хэмнэгдэнэ

Зохион байгуулагчид:

- Хөвсгөл УТХГН-ийн хамгаалалтын захиргаа
- Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

Үйл ажиллагаа

Аялалын маршрут-1: Баянзүрх – Улаан-Уул – Ренчинлхүмбэ – Цагааннуур – Мөрөн

Сум тус бүрт Хөвсгөл орчмын Улсын тусгай хамгаалалттай газар нутгуудыг танилцуулах сурталчилгааны ажил зохион байгууллаа. Үүнд:

1. **ЕБС-ийн сурагчдын** дунд танин мэдэхүйн “АХА” тэмцээн зохион байгуулсан ба энэ нь сурагчдын мэдлэгийг сорихын зэрэгцээгээр тэдний мэдлэгийн хүрээг нэмэгдүүлснээрээ ач холбогдолтой боллоо.



Энэ үеэр сурагчдад Байгаль хамгаалал, ТХГН-ийн талаархи мэдээллийг тараах материал, кино үзвэр, ярилцлага хийх замаар хүргэлээ.

2. Баянзүрх, Улаан-Уул, Цагааннуур, Ренчинлхүмбэ сумдад **байгаль хамгаалах хүүхдийн клубууд** ажиллаад тодорхой хугацаа өнгөрч байгаа. Уулзалтын үеэр хүүхдүүд клубынхаа үйл ажиллагааг танилцуулж хамтран ажиллахаар боллоо.



Баянзүрх сумын сурагчид сумын төвөө хоггүй орчин болгох зорилгоор дэлгүүр, сумын төвийн гудамжинд хогийн сав хийж тавьсан, мөн гудамжинд “Хог байгалийн баялаг биш” гэсэн анхааруулга самбарыг өөрсдийн гарын дор материал ашиглан хийсэн байлаа. Ингэснээр сумын төв хоггүй болсон

ба байгальд ээлтэй хандах хандлагыг багаас нь төлөвшүүлэхээр тус сумын сургуулийн захиргаанаас зохион байгуулж байгаа үр дүнтэй олон арга хэмжээний нэг нь энэ байлаа. Хамгаалалтын захиргааны зүгээс сурагчдын мэдлэгийн санг нэмэгдүүлэх зорилгоор ТХГН-ийн талаар мэдээллийн самбар ажиллуулах, сургуулийн номын фондод байгаль хамгаалах чиглэлээр гарсан видео бичлэгүүдийг өглөө.

Улаан-Уул сумын сурагчдын экоклубын сурагчид жилд 2 удаа (хавар, намар) байгаль хамгаалах сарын аян зохион байгуулдаг ба энэ жилийн намрын аянаа сумын төв орчмын голын эргийн дагуу хогийг цэвэрлэх ажлаар эхлэхээр бэлтгэл ажлаа хийж байлаа.



Улаан-Уул сумын байгаль хамгаалах экоклубын сурагчид

Ренчинлхүмбэ сумын сурагчдын “Ногоон бүс” экоклуб уулзалтын үеэр танилцуулга хийсэн.



Ногоон бүс бүлэг нь 2006 оны 08-р сард 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж, одоогийн байдлаар 97 гишүүнтэй ажиллаж байгаа. Байгуулагдсан цагаасаа хойш дараах ажлуудыг хийсэн.

1. Алтай Соёны төсөлтэй хамтарч байгаль хамгаалах сумын нэг өдрийг зохион байгуулж сурталчилгаа хийсэн.
2. Байгаль орчны танин мэдэхүйн “АХА” тэмцээнийг сурагчдын дунд зохион байгуулсан.
3. 8-р ангийн 2 сурагч Тураг гогойн судалгаа хийж байгаа.



4. Бүлгийн нэг гишүүн Дани явах, туршлага судлах эрхийн бичгээр шагнуулсан.
5. Хар усны рашаанд амарч байгаа хүмүүст сурталчилгаа хийж, тэнд хогийн цэг, сав хийж тавьсан. Мөн концерт тоглосон.
6. 8-р сард Хатгалд болсон баруун бүсийн хүүхдүүдийн чуулга уулзалтанд оролцсон.
7. Шинэ бүлгийн элсний нүүдэл зогсоох талаар Эгч дүү орнууд төсөл, Алтай соёны төсөлтэй хамтран элсийг хашсан боловч хашааг нутгийн хүмүүс аваад түлчихсэн байна. Дараа нь төмөр хашаа хийсэн.
8. “Монгол газар” компанийн охин компани болох “Баяраан” компанийг алт ухахаар ирэхэд нь эсэргүүцэж иргэдээс гарын үсэг цуглуулж Ерөнхийлөгчид илгээсэн.

Ийнхүү 4 сумын сургуулийн 5-11-р ангийн 600 гаруй сурагчдад зориулсан арга хэмжээний дүнд Хөвсгөл орчмын Улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын хамгаалалтын захиргаа нь орчны бүсийн сумдын сургуулийн сурагчдын экоклубуудтэй хамтран ажиллах, тэднийг мэдээллээр хангах, байгаль хамгааллын чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагааг нь дэмжин ажиллах боллоо. Ингэснээр байгаль хамгаалах сурагчдын клубын хүүхдүүдээр дамжуулан иргэд болон бусад сурагчдад сурталчилгааны ажлыг зохион байгуулах бололцоотой. Энэ нь хүүхдийг байгальд ээлтэй, хамгааллын ажилд идэвхитэй, санаачлагатай оролцох сэтгэлгээ төлөвшүүлэх ач холбогдолтой юм.

3. **Сумын иргэдийн хүрээнд хийсэн танилцуулга, сурталчилгааны ажлыг** сумуудад өөр өөр арга хэлбэрээр зохион байгууллаа.



Сумын төвийн дэлгүүр, үйлчилгээний газруудаар орж тэнд үйлчлүүлж байгаа иргэд болон худалдагчдад ТХГН-ийн талаар мэдээлэл өгч, Хөвсгөл орчмын ТХГН-ийн талаарх танилцуулга тарааж, газрын зураг дээр тайлбарлан таниулж, ТХГН-ийн ач холбогдол, үнэ цэнийн талаар тайлбарлалаа.



Цагааннуур сумын иргэдийн дунд зохиогдож байсан үдэшлэгийн хүрээнд үсгээр үг нийлүүлэх, мэдлэг сорих асуулт хариулт, тата тунга зэрэг олон төрлийн уралдаан тэмцээн зохион байгууллаа.

4. **Сумын ЗДТГ, байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй** хийсэн уулзалт Хөвсгөл орчмын УТХГН-ийн хамгаалалтын захиргааны зүгээс танилцуулга хийснээр эхэлж, оролцогч талуудын саналыг сонсож, харилцан ярилцаж тодорхой шийдвэрүүдийг гаргалаа.

- **Баянзүрх суманд** сумын орлогч дарга, ИТХ-ын дарга, зарим багийн засаг дарга, байгаль хамгаалагч, байгаль орчны улсын байцаагчид төсөвт болон ААН-ийн удирдлагуудтай уулзаж ТХГН-ийн тухай танилцуулга хийж, харилцан хамтран ажиллах талаар санал бодлоо солилцож тэдний сонирхсон асуултанд хариулж мэдээ мэдээллийг өглөө. Мөн байгаль орчны хуулийн эмхтгэл болон ан амьтны экологи эдийн засгийн үнэлгээний тайлбар бүхий календарь - байгаль орчны хуулиудын талаар танилцуулга хийж байгаль орчны тасагт нь гарын авлага болгон өглөө.



- **Улаан-Уул сум:** Сумын орлогч дарга Н.Батбаяртай уулзаж ажлынхаа зорилго, чиглэлээ танилцуулан байгаль орчны тасаг, байгаль хамгаалагч, байгаль орчны улсын байцаагч, төсвийн газрын удирдлагууд, сургуулийн нийгмийн ажилтан, бусад төсөл хөтөлбөрийнхөнтэй уулзаж санал бодлоо солилцлоо.



- **Рэнчинлхүмбэ сум:** Сумын дарга засаг дарга Батсуурьтай уулзаж ажлынхаа зорилго, чиглэлийг танилцуулан бусад оролцогчдыг цуглуулан танилцуулга мэдээлэл хийлээ.



- **Цагаан нуур сум:** Цагаан нуур сумын засаг дарга Мягмаржавтай уулзаж зорилго, чиглэлээ танилцуулж бусад оролцогч талуудыг цуглуулан мэдээлэл хийлээ. Тус суманд Алтай соёны төслийн багийнхантай хамтарч сумын удирдлага, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч, сумын ИТХ-ын дарга Буянтогтох, иргэдийн төлөөлөгчидтэй уулзаж ярилцлаа.

Мэдээлэл, сурталчилгааг сайн хийх, хамгаалалтын захиргаанаас холбогдох мэдээллэр тогтмол хангаж орон нутгийн Байгаль орчны тасагтай хамтран ажиллавал илүү үр дүнтэй гэсэн нэгдсэн саналыг гаргалаа.

- **Хөвсгөл аймаг Мөрөн сум:** Мөрөн суманд 09 сарын 29-ны өдрийн 10 цагт аймгийн захиргааны хурлын зааланд боллоо. Уулзалтанд аймгийн БОАЖГ-ны дарга, мэргэжилтнүүд, ГА-ны дарга, УЦУОШ-ний газрын дарга, Цагдаагийн газрын дарга, Хилийн цэргийн урдирдах газрын дарга, Мөрөн сумын засаг дарга зэрэг төрийн болон төрийн бус 27 байгууллагын дарга эрхлэгч нар Далай ван коллежийн 20 гаруй сурагч, 2 багш оролцлоо. Байгууллагын дарга, 4 мэргэжилтэн үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл хийлээ. Оролцогчдыг ажлын 3 хэсэг болгон

чиглэл чиглэлээрээ хамтран ажиллах ажлын төлөвлөгөө болон саналыг гаргуулан хэсэг тус бүрээр нь бусдад нь танилцуулж харилцан ярилцлаа.



“Далай ван” коллежийн аялал жуулчлалын багш Баярхүү танилцуулав.

- ТХГН-ийн захиргаатай хамтран сургалт сурталчилгаа явуулах.
- Хичээл сургалттай холбоотой мэдээлэл авах, мэдээлэл хийх лекц семинар сургууль дээр зохион байгуулах.
- Байгаль хамгаалагчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх. Далай ванд экологи, байгаль хамгааллын анги шинээр нээж байгаа.
- Оюутан залуус зуны амралтаараа ТХГН-ийн хамгаалалтын захиргаатай хамтран хамгаалалтын үйл ажиллагаанд оролцох
- Оюутан залуус байгаль орчныг хамгаалах чиглэлээр Эко-клуб байгуулах хамтран ажиллах, сурталчилгаа явуулах.

Математик, гадаад хэлний “Нийгмийн далай цогцолбор”-ын нийгмийн ажилтан Ундармаа:

ТХГН-ийн уулзалтанд уригдаж ирэхдээ би энд ямар оролцоотой билээ гэж гайхаж бодож байсан. Хөвсгөлийн ТХГН-ийн үйл ажиллагааг танилцуулахаас гадна бидний байгаль хамгаалахад хамтран оролцох оролцоог ярьж байна. Энэ тал дээр орон нутгийн хүүхдийн болон боловсролын байгууллагатай нягт хамтран ажиллах хэрэгтэй. Надад нэг санаа төрлөө. Энэ нь юу вэ? гэхээр хөвсгөл нуурынхаа эрэг дээр хүүхдэд зориулсан “Эко-

зуслан” байгуулж болох юм. Үүгээр дамжуулаад байгаль хамгаалах үйл ажиллагааг холбож өгөхөд дөхөмтэй юм.

Аймгийн харилцаа хот байгуулалтын газрын дарга Цэнд-Аюуш:

ТХГН хамгаалалтын захиргаа нь мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж байх хэрэгтэй байна. Хөвсгөлийн БЦГ-т аялал жуулчлалын зориулалтаар газар олголт замбараагүй болсон. ТХГН-т газар олголтын дээд шатны байгууллага шийдвэрлэдэг. үүнийг хууль бодлогод нийцүүлбэл яасан юм бэ? Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх, газар олголтыг дуудлага худалдаагаар оруулах шаардлагатай. Мөн байгаль орчныг хамгаалахад дараах саналуудыг тусгаж байна.

Зорилго: Байгалиа унаган төрхөөр нь хамгаалцгаая.

1. Хөвсгөл нуурын үзэсгэлэнт байгаль, тусгай хамгаалалттай газар нутгийг “Дэлхийн өв”-д бүртгүүлэх.
2. ТХГН-ийн дэглэмийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.
3. Хамгаалалтын бүсийн дэглэм зөрчиж олгогдсон газар ашиглалтыг хүчингүй болгох /Алаг-Эрдэнэ, Хатгал тосгоны захирагч засаг дарга/
4. ТХГН-ийн хамгаалалтын захиргаа, орон нутгийн засаг захиргаа ажлын уялдаа холбоог сайжруулж нягт хамтран ажиллах.
5. Зөвшөөрөгдөөгүй газарт буудаллаж байгаль орчны бохирдол үүсгэдэг байдлыг бодлогоор зохицуулах арга хэмжээ авах.
6. Бохир ус цэвэрлэх, хог хаягдал булах, устгах төхөөрөмж, байгууламж барих, тээврийн хэрэгсэлээр хангах.
7. Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөлийг, байгалдаа амьдарч байгаа иргэдийг оролцуулан байгуулах.
8. Хүүхэд өсвөр залуу үеийг байгальд өрөвч сэтгэлээр ханддаг сэтгэхүйтэй болгох, залуу үед сургалт сурталчилгааг өдөр тутам хийх.
9. Ус хөрсний шинжилгээг тогтмол хийж байх лаборатори төхөөрөмжтэй болох.
10. Нөхөн сэргээлтийг байнга хийх.
11. Хийгдэж буй судалгааны талаарх мэдээллийг тухай бүр санал солилцож байх.
12. Отгийг байгаль орчныг бохирдуулахгүй байх байдлаар зохион байгуулах.

Онцгой байдлын газар:

1. ТХГН-т гадаадын жуулчид ихээр зорчдог. Энэ иргэдийг Мөрөнд онгоцноос буухад нь ч бүртгэдэггүй, Хатгал очиход нь ч бүртгэдэггүй, ТХГН-т нэвтрэх пост дээр бүртгэлжүүлэх хэрэгтэй.
2. ТХГН-ийн байгаль хамгаалагчид өөр өөрсдийн хариуцсан газар нутаг дээрээ биеэрээ байдаг. Хавар, намрын хуурайшилттай үед энэ байгаль хамгаалагчид гал түймрийн мэдээг цаг алдалгүй мэдээлж байх шаардлагатай. Мэдээлэл солилцож ажиллах.

3. Мөн байгаль хамгаалагчид бие хамгаалах хэрэгсэл ашиглах болон эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх чадвартай байх, мэдлэг боловсролоо дээшлүүлэх ёстой.
4. Хяналтын байцаагчид байршил тодорхойлох, байрзүйн зураг дээр ажиллах чадвартай байх хэрэгтэй.
5. Мөн нуур цөөрмүүд их байдаг, тэр болгон хүн очоод байж чаддаггүй. Энд үхсэн шувуу байдаг. Энэ талаар ТХГ-ын байгаль хамгаалагчид тандалт хийж мэдээлэл дамжуулж ажиллах шаардлагатай байдаг.
6. Мөн өвлийн улиралд хөвсгөл нуурын мөсний аюулгүй байдлыг хангах тал дээр тухайн орон нутагтай хамтран зохион байгуулж пост ажиллуулах хэрэгтэй.

Аймгийн УЦУОШТ-ийн инженер Гүррагчаа мэдээлэл хийв.

1. Уур амьсгалын судалгаа гаргах /олон жилээр/. Тусгай хамгаалалттай газар нь сумдын цаг уурын өртөөтэй мэдээлэл солилцож, хамтран ажиллах.
2. Бэлчээрийн даац, талхлагдалыг тодорхойлох. Хатгал тосгоны цаг уурын өртөөний инженер Отгонням бэлчээрийн даац, талхагдал, бэлчээрийн менежментийн сургалтанд хамрагдсан. Үүний дагуу бэлчээрийн даацын судалгаа хийж байгаа. тухайн жилд орон нутагт хэдий хэмжээний мал өвөлжих талаар мэдээлэл солилцож ажиллах хэрэгтэй.
3. Зуншлага, өвөлжилтийн байдалд үнэлэлт дүгнэлд өгөх
4. Агаар, ус, хөрсний бохирдолтонд шинжилгээ хийж байна. Агууламжийн шинжилгээ хийдэг.
5. Байгалийн гамшигийн тухай урьдчилан сэргийлэх мэдээгээр шуурхай зохион байгуулж анхаарч ажиллах.
6. Ой хээрийн түймэр болон ган тайлах ажиллагаанд хамтран ажиллах.
7. Нуур судлалын өртөөний дэргэд БОШЛ-ыг ажиллуулах. Нуурын усны элементийн судалгаа явуулах 2 дахь лабратори байгуулж хамтран ажиллах.
8. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчидтэй хамтран ажиллах /жуулчны баазууд, НИТАЖ эрхлэгчид, отог/
9. Жуулчны статистик мэдээлэлийг бүртгэх.
10. Жуулчны аюулгүй байдал хангах тал дээр хамтарч ажиллах.
11. Хог хаягдал орчны бохирдол асуудал дээр бодлого гаргаж ажиллах.
12. БО-ны мэдээллийн сан бүрдүүлж ажиллах.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Дуламсүрэн:

Хөвсгөл аймаг нь аялал жуулчлалын бүс нутаг төдийгүй Монгол Улсын аялал жуулчлалд тодорхой хувь нэмрээ оруулж байна.

1. Аялал жуулчлал, ан агнуур, ой ургамал, орчны бохирдол, ус агаар, хог, хаягдал, БО-ны мэдээллийн сангуудын талаар харилцан бие биеэ дэмжиж, мэдээллээ солилцож ажиллах нь чухал юм.

2. Аялал жуулчлалын тухай хуулийг шинэчлэх, УИХ-д суугаа гишүүддээ өөрсдөө саналаа боловсруулж хүргэх.
3. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчидтэй хамтран ажиллах. Хэдэн жуулчин, ямар улсаас, юу сонирхож ирсэн?
4. Жуулчдын статистак бүртгэл мэдээллийг гаргаж байх.
5. Жуулчдын аюулгүй байдлыг хангах.
6. БО-ны сайдын 1996 оны тушаалаар батлагдсан “Мэдээллийн сан бүрдүүлэх журам”-ын дагуу сан бүрдүүлэхэд нэгдмэл байж, мэдээллээ солилцож харьцуулж ажиллах. Танай мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн хэрхэн мэдээллээ бүрдүүлж байгаа талаар мэдээ солилцох мэдээллүүд нэгдмэл байвал илүү үр дүнтэй юм болов уу. Мэдээллийн сангын журмын дагуу.
7. Нуурийн эргээр байрласан аялал жуулчлалын бааз нэртэй амралтын газрууд нуурыг болон нуур орчмын газрыг бохирдуулж, байгалийн унаган төрхийг алдагдуулж байна. Иймд энэ амралтын газрыг нуурын эргээс нүүлгэж 10-15 км холдуулах. Стандартын дагуу.
8. Нуурын эрэг орчимд аялал жуулчлалаар яваа хүмүүс өдрийн цагаар очиж байгалийн сайхныг бишрээд буцдаг. Энэ хүмүүст зориулсан түр байрлах газар байвал байгаль сүйдэх нь бага байна.
9. Нуур орчимд байгаа баазуудын олон салаа замыг нэг болгох, замыг нь сайжруулах юмуу, хатуу хучилттай болгох.
10. Нуур орчмын амралтын газруудын өнгө үзэмжийг сайжруулах чиглэлрүү анхаарлыг нь хандуулах, орчиндоо үхрийн нүд, чацаргана болон бусад жимс самрын бут сөөгийг тарималжуулдаг болгох.
11. Аялал жуулчлалын тухай хууль нь орчин үед аялал жуулчлалын хурдыг гүйцэхгүй хоцрогдсон хууль болсон байна. Аймгийн аялал жуулчлалын бизнес төлөвлөлтөнд ТХГН-ийн зүгээс санал оруулах. Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх тал дээр хамтран ажиллах.

Аймгийн МХГ-ын Байгаль орчны Хяналтын Улсын байцаагч Даваасүрэн:

1. ТХГН-ийн дэглэм, Усны эрүүл ахуй хамгаалалтын бүсийн дэглэм зөрчиж олгогдсон газруудын захирамжийг хүчингүй болгох /Хатгал, Алаг-Эрдэнэ/
2. Хамгаалалтын захиргаа нь Хатгал, Алаг-Эрдэнэ сумын засаг захиргаатай нягт хамтын ажиллагааг сайжруулах /БОАЖ-ын талаар/
3. Ханх сумын төвийн нуурын эрэг дагуух газруудыг нүүлгэн шилжүүлэх /бааз/
4. Бохир ус цэвэршүүлэх нэгдсэн байгууламж барих.
5. Хог хаягдлын төвлөрсөн цэгт хог хаягдал булаах шатаах зориулалтын төхөөрөмж суурилуулан ашиглах. Бодлогоор зохицуулах хэрэгтэй.
6. Хөвсгөл нуурын усыг болон хөрсийг өдөр тутам шинжилгээнд хамруулах бололцоог бүрдүүлсэн лаборатори төхөөрөмжийг байгуулан ашиглах. Бактерилогийн шинжилгээг хийхдэг болох.
7. Хөвсгөл нуурыг Дэлхийн байгалийн өвд бүртгүүлэх. Үндэслэл боловсруулах.

8. Хөвсгөл нуур орчимд отоглох цэгийг байгаль орчин бохирдуулахгүй байдлаар тохижуулах, ОО-ын асуудлыг шийдэх, замбаруугүй буудаллах байдлыг бодлогоор сайн зохицуулах.
9. Залуу үед сургалт сурталчилгааг сайн хийж өгөх.
10. Хатуу, шингэн хог хаягдлын тээврийн хэргслийн хоцрогдсон асуудал хүнд байна.
11. Нөхөн сэргээлтийн асуудал хангалтгүй байдаг. Нөхөн сэргээлт дээр ТХГН-аас онцгой анхаарал тавих хэрэгтэй.
12. Хийгдэж буй судалгааны талаар мэдээлэл солилцох. Иргэдэд товч мэдээлэл хийж байх.

Цагдаагийн дэд хурандаа Батдэлгэр:

1. ТХГ-аар дайран өнгөрч байгаа гадаад, дотоодын жуулчдын овог нэр, регистрийн дугаар, утасны дугаар, машины марк, номеруудыг нэгдсэн санд оруулах, аль баазад хэд хоног амрах бүртгэл хийж байх.
2. Ханх суманд пост байгуулах.
3. Тухайн нутаг дэвсгэрийн цагдаагын хэсгийн төлөөлөгч, цагдаа нартай хамтран ажиллах, ажлын төлөвлөгөө гаргах, сумын засаг даргатай байгуулсан гурвалсан гэрээнд тодорхой заалт оруулах
4. Хогтой холбоотой асуудал байна. Хог модоор дүүрсэн байна. Тухайн орон нутгын төрийн захиргаа болон төрийн бус байгууллагуудтай хамтран хаягдал хогны асуудлыг шийдэх.
5. Жуулчны баазууд ойр орчныхоо цэвэрлэгээг тодорхой м²-т хийж тухайн орон нутгийн захиргаанд /нуур хамгаалалтын захиргаанд/ шалгуулж байх.
6. Усан зам, мөсөн замын байцаагчтай болох. Усан, мөсөн замын онгоц, завинд стандарт тогтоох, маршрутанд хязгаарлалт хийх.
7. Усан онгоц, завины жолооч эрхийн үнэмлэхтэй байх хэрэгтэй.

Уулзалтанд оролцсон иргэдийн санал

1. Мөрөн сумын ЕБС-уудтай нягт хамтран ажиллах.
2. Сургалт сурталчилгааны ажлыг өргөтгөх.
3. ТХГН-уудыг хамгаалахад иргэн хүний үүрэг оролцоог нэмэгдүүлэх.
4. Онцгой байдлын албууд болон БО-ны алба, Эрүүл мэндийн газар, мэргэжлийн хяналтын газар, мал эмнэлэгийн мэргэжлийн хүмүүсийн хүч оролцоог ашиглах, тэднийг сургах, бэлтгэх, хамтран ажиллах
5. Хүүхдийн цэцэрлэг, сургуулиудад байгаль ээжээ унаган төрхөөр нь байлгах, хайрлан хамгаалах хичээлийг сургалтын праграммд оруулах
6. Ой модны зохистой хэрэглээг бий болгох
7. Байгаль хамгаалах ажлыг сайжруулах, байцаагчидын хоорондын ажлын уялдааг сайжруулах
8. Байгалиа хамгаалахдаа ТХГ-ын ХЗ-ны ажилчид хамгаалахаас гадна энэ бүсийн иргэдийн оролцоог сайн ашиглах, тэднээр сайн дурын урамшуулалттай идэвхитэй хамгаалуулах, мөн мэдээлэл тэднээс авч байх хэрэгтэй байна.

9. ТХ-ын бүсэд байгаа жуулчны бааз, ААН зэргийг онцгой анхаарах шаарлагатай юмуу даа
10. Нуур болоод ТХГ-т амьдардаг иргэд нөхөрлөл байгуулан ажиллуулах хэрэгтэй
11. Байгаль ээжээ хамгаалах талаар яриа ухуулага суртчилгаа энэ талын ажлыг цаг ямагт хийж байх
12. Хүүхэд болон өсвөр үеийнхэнд байгаль орчноо хайрлах нигүүлсэнгүй сэтгэлтэй болгох шаардлагатай юмуу
13. Байгальтай зүй бусаар харьцахад хэзээ нэгэн цагт байгаль танаас хариугаа авна гэсэн энэ зүйлээр мэдээлэл сайн өгөх
14. Хүн байгалийн нэгэн амьтан юм. Иймд байгаль дэлхийгээтэйгээ зөв харьцаж сурах нь хүн бүрийн үүрэг билээ
15. Ил задгай гал түлэх асуудлыг шийдэх
16. Жуулчны баазууд мод тарих, цэцэрлэгжүүлэлт хийх
17. Байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэлтэнд мэдээллийг нэгтгэж ажиллах
18. Уур амьсгалын судалгаа, эх үүсвэрийг гаргаж өгөх
19. Бэлчээрийн даац талхлалтыг гаргах
20. Зуншлага өвөлжилтийн байдалд үнэлэлт өгөх
21. Агаар ус хөрсний бохирдолын шинжилгээ хийх
22. Байгалын гамшигийн тухай урьдчилсан мэдээлэл өгөх
23. Ой хээрийн түймэр болон ган тайлах ажиллагаанд хамтран ажиллах
24. Хөвсгөл аймгийн байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдтэй хамтран ажиллах, ойрын үед уулзалт зохион байгуулах
25. 50-р өргөргөөс хойш ашигт малтмалын хайгуул ашиглалт явуулахыг хориглосон Их хурлын хуулийг хэрэгжүүлэх ажлыг холбогдох газруудтай хамтран ажиллах
26. Сум тосгоны байгаль хамгаалах байгууллага хүмүүстэй нягт хамтран ажиллах
27. Иргэдийн нөхөрлөлийг дэмжиж сайн ажиллаж байгаа байгууллага нөхөрлөл байгаль хамгаалагч, аялал жуулчлалын бааз, иргэнийг шалгаруулж шагнал урамшуулал өгөх , арга туршлагыг нь нийтэд сурталчилах зэрэг ажлыг жил бүр зохион байгуулах
28. Хатгалын жуулчны баазуудын уулзалт дээр тавьсан санал санаачлагыг хамтран хэрэгжүүлэх
29. Өргөн уудам орон зайд байгал хаигаалах ажлыг байгууллага, оло нийтийн хөдөлгөөнд түшиглэн хүч тусалцааг нь авч ажиллах
30. Сургалтын үйл ажиллагааг орон нутгын иргэдийн болон боловсролын байгууллгатай хамтран зохион байгуулах
31. Тэмцээн уралдаанаар үйл ажиллагааг хязгаарлахгүй байх
32. ТХГ-ыг түшиглэсэн Эко-зуслан байгуулах. Хүүхэд амрах зорилгоор
33. Мэргэжлийн сургагч багш нарын дэмжлэг авах
34. Хөвсгөл нуур орчмын газар ашиглалтын менежментийн төлөвлөгөөг холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор боловсруулж хамтран ажиллах
35. ТХГН-ийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж газрын тухай хуультай уялдуулах
36. БЦГ-т аялал жуулчлалын зориулалтаар газар олгохдоо менежментийн төлөвлөгөөг үндэслэн тодорхой төрөл ангилалтай олгож хэвших

37. Газар олгохдоо орон нутгын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлж, төсөл сонгон шалгаруулалтаар болон ухуулга сурталчилгаагаар шийдвэрлэдэг болгох
38. Ой хээрийн түймэр гарсан үед ТХГ-ын байцаагчдын мэдээлэл хэрэгтэй байдаг. Сум орон нутагт байр зүйн зураг байдаггүй. Хяналтын байцаагч нарыг байр зүйн зураг дээр солбилцол тогтоож сургах
39. ТХГ-ын байцаагчидад завь холбооны хэрэгсэл, бие хамгаалах хэрэгсэл болон осол гэмтэлд өртсөн хүмүүст анхны тусламж үзүүлэх чадварт суралцуулах
40. Сум орон нутгаас алслагдмал нуур цөөрөмд шувуу үхэх байдал их ажиглагддаг тул ТХГ-ын байцаагч нарын мэдээлэл хэрэгтэй байдаг
41. Мөсөн замд тодорхой хугацаанд зөвшөөрөл өгч маршрут болон пост гаргаж ажиллаж байх
42. Хөвсгөл нууранд ашиглаж байгаа завь болон усан онгоцны жолооч нарыг үнэмлэхжүүлэх
43. Сумын байгаль орчны тасагтай төлөвлөгөө гарган нягт хамтран ажиллах, чиглүүлэх, Байгаль хамгаалагчдын хамтын ажиллагааг бэхжүүлэх.
44. Сургуулиудын “Эко клуб”-үүдийн үйл ажиллагааг дэмжиж, чиглүүлэгч багштай хамтран ажиллах, хүүхдүүдээр байгаль орчны сурталчилгаа хийлгэх, биологийн кабинетыг тохижуулах тал дээр төрөл бүрийн дэмжлэг авах. Ирээдүйн боловсон хүчин бэлтгэх.
45. Байгаль орчныг хамгаалах бүлэг нөхөрлөлийн үйл ажиллагаа дэмжих, хамтран ажиллах.
46. Олон улсын төсөл хөтөлбөрүүдэд хийх гэж буй ажлынхаа санал тавьж дэмжлэг авах. Зардлаа бууруулах боломж хайх.
47. ТХГН-ийн талаар мэдээлэл, сургалт сурталчилгааг ард иргэдэд байнга зохион байгуулж байх.
48. Иргэдэд амьжиргааг дээшлүүлэх сургалт явуулах.
49. Байгаль хамгаалах ажилд оюутан залуучуудыг татан оролцуулах тэднийг мэдээллээр хангах.
50. Байгаль орчныг хамгаалах хамтын оролцоог бодлогоор зохицуулах. Гэндсэн бодлоготой ажиллах.
51. Мөн багийн засаг дарга нарыг зөв мэдээллээр хангах, тэднийг чиглүүлэх.

Уулзалтын үр дүн:

- Сумдад ажиллах хугацаандаа оролцогч талуудыг өргөн хүрээтэй оролцуулан ТХГ-ын зорилго, үйл ажиллагаа, үнэ цэнийг сурталчилах, танин мэдүүлэх, орон нутгийн Засаг захиргаа, ард иргэдэд мэдээлэл хүргэх, байгаль орчноо хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, бүлэг нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих, орчны бүсийн ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, орлогын эх үүсвэрийг бий болгох тал дээр санал бодлоо солилцож боломжуудыг судалж хамтын ажиллагааны гэрээ байгуулж харилцан бие биедээ үүрэг, хариуцлага хүлээж, бие биенээ дэмжин хамтран ажиллахаар санал нэгтэй тохиролцлоо.

- Сумын байгаль орчны бодлогыг нэгтгэн барьж ажиллах сумын засаг даргын орлогчоор ахлуулсан байгаль орчны тасагтай ТХГ-ын захиргаа болон байгаль хамгаалагчид хамтран ажиллах боллоо.
- Иргэдийн нөхөрлөл болон сурагчдын экоклубтэй хамтарч ажиллах нь чухал гэдгийг байгууллагын удирдлага, мэргэжилтнүүдийн түвшинд ойлгосон.
- Сумын удирдлага, иргэдэд сурталчилгааг тасралтгүй гинжин холбоотой өгч байхын чухлыг ойлгож цаашид багийн төвүүдийг түшиглэн иргэдтэй уулзах уулзалтыг зохион байгуулах, орчны бүсийн сумдад мэдээлэл сурталчилгааны самбар үзүүлэн гаргахад хөрөнгө мөнгө гаргаж мэдээллийн самбаруудыг хийж байрлуулах боллоо.
- Аймаг, сумын түвшинд гарсан саналуудыг үндэслэн ажлаа төлөвлөхөд дөхөмтэй болсон.
- Сумын удирдлага, ард иргэд ТХГН-ийн ач холбогдол үнэ цэнийг ойлгосон.

Дүгнэлт:

- Оролцогч талууд болон НҮБХХ-өөс санхүүжүүлж БОАЖЯ-наас хэрэгжүүлж байгаа Монголын алтай соёны уулархаг мужийн экобүсийн биологийн төрөл зүйлийг ард иргэдийн оролцоотойгоор хамгаалах төсөлтэй нягт хамтран ажиллаж тэдний байгуулсан бүлэг нөхөрлөлүүдийг дэмжин ажиллах, цаашид бүлэг нөхөрлөл байгуулахад санаачлагатай ажиллах шаардлагатай байна.
- ТХГН-ийн хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа буюу байгаль хамгаалах үйлсэд олон нийт идэвхитэй оролцоход бэлэн байгаа нь тэдэнтэй хийсэн уулзалтын хандлагаас харагдаж байна. Гагцхүү энэ хандлагыг хамгаалалтын захиргааны зүгээс удирдан зохион байгуулах шаардлагатай болох нь харагдаж байна.
- Уулзалтаас гарсан саналыг үндэслэн ажлаа төлөвлөж шаардлагатай хөрөнгө төсвийг байгууллагын төсөвт тусгах болон оролцогч талуудын хандив тусламж, тэдний оролцоотойгоор хийх боломжийг хайж ажиллах.
- Суманд ажиллаж байгаа байгаль хамгаалагчдыг идэвхтэй оролцуулах өөрсдөөр нь сурталчилгааны ажлыг бие даан зохион байгуулуулах
- Мэргэжилтнүүд уулзалтын талаар өөр өөрсдийн хариуцсан чиглэлээр хамтран ажиллах боломжуудыг судалж хамтран ажиллах талаар төлөвлөгөө гарган ажил хэрэг болгох тал дээр анхаарч ажиллавал зүйтэй байна. Мөн төлөвлөсөн ажлаа гүйцэтгэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бий болгох, мөнгө олох гарц, дэмжлэг үзүүлэх төсөл хөтөлбөрүүдийг судлах ёстой юм байна.
- Хамгийн гол нь мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг сайн хийж өгөх нь зүйтэй.
- Хамгаалалтын захиргаа үйл ажиллагаандаа хамтын оролцоог бий болгосноор үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдэж, ингэснээр тухайн үйл ажиллагааны зардал хэмнэгдэж болох юм.

Тайлан бичсэн: Хөвсгөл УТХГН-ийн хамгаалалтын захиргааны мэргэжилтэн

С.Наранцэцэг
Т.Хулганаа
Үржинбадам
2009,10,10